МЭДЭЭ · 2020 оны 6-р сарын 8

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ЗУРАГТ ХУУДАС ГАРГАЖЭЭ



Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар нь "Прокурор оролцох боломжтой иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа"-ны талаар танилцуулсан зурагт хуудас гаргажээ. Тус зурагт хуудсыг төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог сурталчлан таниулах зорилгоор гаргасан бөгөөд дүүргийнхээ төрийн байгууллагууд болон цагдаагийн хэлстүүдийн мэдээлэл, лавлагааны цэгээр дамжуулан иргэдэд тараасан байна.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ПРОКУРОРЫН ГАЗАР

Прокурор нь төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, төр, нийтэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авна.

2020 он

Монгол улсын Үндсэн хууль:

56 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, **шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно**

Прокурорын тухай хууль :

17 дугаар зүйл. Прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох

17.1.Прокурор хуульд заасан тохиолдолд дараахь шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно:

17.1.3.захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх.

41.1. Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл, тайлбар, гомдол гаргана.

20.1.*Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл* төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

31.1. .Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3150